

United Nations Conference on Trade and Development

National Workshop on

Fostering Integration of the Mongolia Downstream Value Chain of Meat into Regional Value Chains

29 January 2021, Ulaanbaatar, Mongolia

Махны зах зээлийн судалгаа

(Meat Market Research)

By

R. Perez, UNCTAD, and M. Boldbaatar, MICC

The views expressed are those of the author and do not necessarily reflect the views of UNCTAD.

Махны зах зээлийн судалгаа

“Далайд гарцгүй, түүхий эдийн хамааралтай хөгжиж буй орнуудыг бүс нутгийн болон дэлхийн үнэ цэнийн гинжин хэлхээнд нэгтгэх нь: Монгол Улс - Махны зах зээл”

2021 оны 1-р сар

Агуулга

1. Зорилтот 5 зах зээлийн судалгаа

- Хятад
- Орос
- Япон
- Вьетнам
- Казакстан

2. Махны экспортын олон улсын стандартад нийцсэн байдал - Зах зээлд нэвтрэх заавар

- Хятад
- Орос
- Япон
- Вьетнам
- Казакстан

3. Хятадын зах зээлд нэвтрэх

- Одоогийн гүйцэтгэл
- Бэрхшээл ба боломжууд
- Экспортын хөгжлийн үе шатууд

4. Дүгнэлт ба зөвлөмж


- Байгууллага
- Арилжаа

1. Зорилтот зах зээлийн судалгаа – Хятад улс


Гол статистик

- Хятад бол 1.4 тэрбум хүрэхгүй оршин суугчтай дэлхийн хамгийн **олон хүн амтай** улс юм.
- Хятадын хүн ам 2018 онд **75 сая гаруй тонн** мах хэрэглэсэн байна
- OECD-ийн судалгаагаар нэг хүнд ногдох махны хэрэглээ **8%-иар** өснө гэж таамаглаж байна.
- Үхрийн мах нь хамгийн өндөр өртөгтэй импортын бүтээгдэхүүн байсан ба дундажаар **8 тэрбум ам.доллар** хүрчээ.


Зураг 1. 2010-2019 оны хоорондох нийт махны импортын хэмжээ



Зураг 2. 2016-2020 оны хоорондох Хятад улсын хүн амын нэг хүнд ногдох махан бүтээгдэхүүний хэрэглээ (кг-аар)



Зураг 3. Хятад улсруу мах нийлүүлэгч улс орнууд /2019 он/



Дэлхийн махны хэрэглээ жилд 2% -иар нэмэгсэн ба өсөлтийн тэн хагас нь Хятадаас гаралтай байв

1. Зорилтот зах зээлийн судалгаа – Хятад улс

Гол статистик


- Дэлхийн банкны судалгаагаар Хятад улсын махны хэрэглээ сүүлийн 30 жилийн хугацаанд нийтдээ дөрөв дахин нэмэгдсэнийг мэдэгджээ.
- Саяхан Ковид-19 вирусын дэгдэлт гарч байгаатай холбогдуулан Хятадын махны импорт 2020 оны эхний дөрвөн сард өмнөх оны мөн үеэс 82% -иар өсч **3.03 сая тонн**д хүрчээ.
- Дотоодын махны үйлдвэрлэлтэй холбоотой байгаль орчны тулгамдсан асуудлуудаас болоод БНХАУ-ын импортын **махны эрэлт ирээдүйд хүчтэй** байх төлөвтэй байна.

Хэрэглэгчийн сонголт

- Хятад улсын олон нийт **гахайн махыг** түлхүү хэрэглэдэг боловч Африкийн гахайн ханиад дэгдсэнээс болж 2019 онд үхэр, хонь болон хонь ямааны махны импорт жилдээ дундажаар 60% ба 24%-иар тус тус өсчээ.
- Хятадын хүн ам махны тэжээллэг чанарыг чухалчилдаг учраас **үхэр** ба **хонины махыг** илхэрэглэхийг зорьдог.



Зураг 4. 2010-2019 оны хоорондох Хятад улсын хүн амын нэг хүнд ногдох махны хэрэглээ / кг-аар /



Source: OECD-FAO

1. Зорилтот зах зээлийн судалгаа – Орос улс


Ерөнхий

- Монгол улсын Гаалийн ерөнхий газрын мэдээллэж байгаагаар Орос улс нь Хятадын дараа ордог Монголын **томоохон импортлогчдын нэг** юм.
- Орос улс жилд **дунджаар 5.38 сая ам.долларын** адууны махыг Монголоос импортолдог нь ОХУ-ын нийт махны импортын 1.6 хувийг эзэлж байна.
- Орос нь Европын хамгийн их хүн амтай улс бөгөөд Хятад улсын хүн амтай харьцуулахад нэг хүнд ноогдох махны хэмжээ **28%-иар илүү хэрэглэдэг**.



Гол статистик

- 2028 он гэхэд Оросын нэг хүнд ноогдох махны хэрэглээ **6%-иар өсөх хандлагатай байна**.
- 2019 онд ОХУ-д нийт махны үйлдвэрлэлийн **45% -ийг шувууны мах эзэлж** байсан боловч хэт их үйлдвэрлэлтээс болж шувууны зах зээл цаашид өсөхгүй байна. Нөгөөтэйгүүр, экспортын боломжууд ихэсч гахай болон үхэрний махны хэрэглээ өсөх хандлагатай байна.

Зураг 5. Оросын хүн амын нэг хүнд ноогдох махны хэрэглээ, төрлөөр нь авч үзвэл 2010-аас 2020 оны хооронд



Зураг 6. 2010-аас 2019 оны хоорондох нийт махны импортын хэмжээ /тонноор/



Оросын худалдан авагчдын **75%** нь аливаа мах махан бүтээгдэхүүний эко, био ба органик шошготой эсэхэд анхаарлаа хандуулдаг байна.

1. Зорилтот зах зээлийн судалгаа – Япон улс


Ерөнхий

- Япон улс нь Монголоос адууны мах импортлодог гурван улсын нэг бөгөөд 2018 онд нийтдээ 2.4 сая долларын өртөгтэй хонь, ямааны мах худалдаж авчээ.
- Япон дахь махны хамгийн том нийлүүлэгчид нь АНУ, Австрали, Канад байсан бөгөөд нийт импортын **60 гаруй хувийг** бүрдүүлжээ.


Хэрэглэгчийн сонголт

- Сүүлийн үед Япон улсын дундаж орлого өсч, дэлгүүр сүпермаркетын тоо хэмжээ нэмэгдсэнээр хүн амын хоолны дэглэмд эрс өөрчлөлт гарч улмаар **будaa болон загасны хэрэглээ буурчээ**.
- Сүүлийн 40 жилийн хугацаанд хотын хэмжээнд хэрэглэсэн үхрийн мах, гахайн махны хэмжээ тус тус **160%, 90% -иар өссөн** байна.

Зураг 7. 2010-2019 оны хооронд Япон улсын хүн амын нэг хүнд ноогдох махны хэрэглээ /кг-аар/



Зураг 8. Япон улсруу мах нийлүүлэгч улс орнууд /2019 он/



Гол статистик

- 2019 онд Япон улс далай болон агаараар нийт 1.9 тэрбум долларын өртөгтэй **2.3 сая тонн** махыг импортлосон.
- 2019 онд Японы нийт гахайн махны импорт хамгийн их буюу **4.6 тэрбум ам.доллар хүрсэн** ба дараа нь үхрийн үхрийн хөлдөөсөн мах /3.5 тэрбум ам.доллар/, шувууны мах /1.3 тэрбум ам.доллар/ тус тус оржээ.

Японы хүн ам 2028 он гэхэд 4% -иар буурах боловч нэг хүнд ногдох махны хэрэглээ 5% -иар өсч, махны хэрэглээ 288 мянган тонноор ихэснэ.

1. Зорилтот зах зээлийн судалгаа - Вьетнам

Гол статистик


- Вьетнамын эдийн засаг 2018 онд **7.1% -иар өсөж**, дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж буй орнуудын аравдугаарт жагсав. / Дэлхийн банк /
- Вьетнамын эдийн засаг, 96 сая хүн амын махны эрэлт өсөхийн хэрээр 2014 оноос хойш Монголоос импортолсон нийт импорт **161% -иар өссөн** байна.
- 2000-2018 оны хооронд Вьетнам махны хэрэглээ **180% -иар өсөж 52.49 кг/хүн** болжээ. Махны хэрэглээ 2028 он гэхэд 14% -иар буюу 776 мянган тонноор өснө. Мөн энэ хугацаанд махны хэрэглээний өсөлт хүн амын 8% -ийн өсөлтөөс давах болно.
- Вьетнамын тахиа шувууны махны импорт 186 сая ам.долларт хүрч, **нийт импортын 49%-ийг** эзэлж байна.
- Үхрийн махны импортын хэмжээ **жилд дунджаар 29% -иар өсөж** 244 сая долларт хүрсэн.



График 9. Вьетнам дахь нийт мах нийлүүлэгч /2019/



График 10. 2010-2017 оны хоорондох нийт махны импортын хэмжээ, тоогоор



Хэрэглэгчийн сонголт

- Вьетнамын ихэнх хэрэглэгчид супермаркетаас боловсруулсан буюу хөлдөөсөн мах гэхээсээ уламжлалт ил захаас **шинэ мах авахыг илүүд үздэг**.
- Вьетнамын хэрэглэгчдийн дунд **импортолсон хүнсний аюулгүй байдлын стандарт илүү өндөр чанартай** гэсэн үзэл бодол нь мах импортлох эрэлт өндөр байгааг харуулж байна.

1. Зорилтот 5 зах зээлийн судалгаа - Казахстан




2019 онд
Казахстаны
нийт махны
хэрэглээ **1.1**
сая тонн
байсан бол
нийт махны
үйлдвэрлэл
ердөө **0.9**
сая тонн
байв.

Ерөнхий

- Гахайн махны хэрэглээ бага, **нэг хүн жилд дунджаар 6 кг л иддэг**. Казахстаны хэрэглэгчид мөн хонины махыг жилд нэг хүн ойролцоогоор 8.1 кг хэрэглэдэг.
- АНУ нь Казахстаны хамгийн том мах нийлүүлэгч хэвээр байгаа бөгөөд 2019 оны байдлаар 128 сая ам.долларын мах, дотоод эрхтний экспорт хийгдсэн нь **Казахстаны нийт махны импортын 47% -ийг эзэлсэн байна**. Казахстан нь адууны махыг ихэвчлэн Монголоос импортолдог (2019 онд 580 мянган ам.доллар).
- Хамгийн том мах бэлтгэн нийлүүлэгчид нь АНУ, Беларусь, ОХУ бөгөөд **нийт импортын 80 гаруй хувийг эзэлж байна**.
- Шашны шалтгаанаар гахайн мах тус улсад **тийм ч их онцлог шинжтэй байдаггүй**.


Зураг 12. Казахстан улсын нэг хүнд ногдох махны хэрэглээ 2010-2019 онуудад /кг-аар/



Гол статистик

- Казахстанчууд Монголчуудтай адил махыг ихээр хэрэглэглэдэг. 2019 онд **нэг хүнд ногдох махны хэрэглээ 47 кг** байсан бол дэлхийн нэг хүнд ногдох махны хэрэглээ 34 кг байв.
- Үхрийн мах бол **нэг хүн дунджаар 20 кг** хэрэглэдэг буюу хамгийн эрэлттэй төрөл юм; 2010-2019 оны хооронд нэг хүн ойролцоогоор 15 кг хэрэглэснээр шувууны мах удаах байранд оржээ.

Зураг 13. Казахстан руу мах нийлүүлэгч орнууд /2019/




2. Зах зээлд нэвтрэх заавар – Хятад улс

Ерөнхий

- Тэдний экспортын дийлэнх хэсэг нь Хятадын зүүн ба зүүн хойд хэсгүүд буюу Шанхай, Гуанжоу, Тяньжинаар дамждаг. Монголын экспортын хувьд **Өвөр Монголын Өөртөө Засах Орноор дамждаг.**



- Дотооддоо шинэ махны түгээлтийн 3 сувгаар дамжуулан хийдэг: жижиглэн (51%), хүнсний үйлчилгээ (28%), байгууллагууд (21%).




Сорилт

- Захууд ихэвчлэн ариун цэврийн асуудлаас болж Хятадын эрх баригчдын **хатуу хяналт дор байдаг** бөгөөд Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт (НАССР)-ын дагуу эдгээр газруудаас махан бүтээгдэхүүний худалдааг зогсоох нь элбэг байдаг.

Стратеги

- Зах зээлд нэвтрэхэд хамгийн тохиромжтой стратегийг олж авахын тулд экспортлогчид Хятад дахь тогтвортой дундын бөөний худалдаачид, агентууд, брокерууд, ложистикийн дэмжлэг үзүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг ашиглаж болно.
- Монголын мах экспортлогчдын хувьд Хятадын импортын тогтворжсон компаниуд нь Two even Xin HSBC Худалдаа, Эрээн хотын Xiang Hong Trade, Эрээн хотын Minghaoweioye Economic and Trade, Бээжин хотын Hongye Hong Food Trade зэрэг юм.

Зураг 14. Хятад дахь түгээлтийн сүлжээ



Хүснэгт 1. Холбогдох худалдан авагч, импортлогч, борлуулагчдын жагсаалт

Компанийн нэр	Төрөл	Вэбсайт
Dalian Kowa Foods Co	Импорт/Түгээлт	http://www.kowafoods.com.cn/
Dalian Zhenxin Canned Food	Импорт/Түгээлт	http://www.cansi.net/
Henan Star Animal ByProducts	Импорт/Түгээлт	http://www.henanstar.com/


2. Зах зээлд нэвтрэх заавар – Орос улс

Ерөнхий

- ОХУ 2012 онд ДХБ-д элссэн хэдий ч импортын хүнсний бүтээгдэхүүнийг Оросын агентлаг импортын хүнсэнд тавих хяналт нь нарийн төвөгтэй, чирэгдэл ихтэй хэвээр байна.
- Хүнсний импортлогчдын оффис, агуулах нь ихэвчлэн Санкт-Петербург, Владивосток зэрэг **боомт хотуудад** эсвэл хэрэглээний гол төв болох нийслэл Москва хотод байрладаг.
- Хүнсний үйлдвэрүүд Оросын ихэнх бүс нутагт байрладаг ч томоохон үйлдвэрүүд нь ОХУ-ын **Төв/Өмнөд ба Уралын хэсэгт хот суурин газрын ойролцоо** байрладаг.
- ОХУ дотроо ихэнх бүс нутаг хоорондын хүргэлтийг **ачааны машинаар** гүйцэтгэдэг. Холын зайд хүргэхэд заримдаа төмөр зам ашигладаг.



Зураг 15. ОХУ дахь түгээлтийн сүлжээ



ОХУ-ын зүүн ба баруун хэсгүүд нь хоорондоо **6000 милийн зайтай** тул ихэвчлэн нийлүүлэлт, түгээлтийн тусдаа суваг бүхий бие даасан зах зээл болж ажилладаг.

- Оросын **хурдацтай өсөн нэмэгдэж буй зах зээлийг** онцолдог боловч хууль эрх зүйн орчин, экспортын журам нь шүүмжлэлтэй байна.
- Нэмэлт мэдээллийг **“ОХУ-ын экспортлогчдын гарын авлага 2019”**, **“Retail Foods Moscow”**-с авах боломжтой.

2. Зах зээлд нэвтрэх заавар – Япон улс




Зураг 16. Япон дахь түгээлтийн сүлжээ

Стратеги

- Японы махны зах зээлд гарахын тулд экспортлогчид **Японд оффисоо байгуулах** эсвэл **зуучлагчтай түншлэх** хэрэгтэй.
- Хамтран ажиллах зөв түншээ сонгох нь Японы махны зах зээлд нэвтрэх чухал хэсэг юм.
- Махан бүтээгдэхүүнийг ихэвчлэн **жижиглэнгийн худалдаагаар дамжуулан** хэрэглэгчдэд борлуулдаг тул экспортлогчид супермаркеттай хотуудыг зорилт болгох хэрэгтэй.
- Худалдааны компаниудтай түншлэх нь үйлчлүүлэгчдэд илүү хүрэх давуу талтай; харин дистрибьютер/агент эсвэл бөөний худалдаачидтай түншлэх нь хүнсний үйлчилгээний салбарт борлуулахад давуу талтай.

Ерөнхий

- Боломжит түншүүдтэй холбоо тогтоох, тэдэнтэй харилцах зөв аргыг мэдэх нь чухал. Японы худалдааны түншүүдтэй бизнес эрхлэхдээ соёлын болон бизнесийн тодорхой ёс зүйг анхаарч үзэх хэрэгтэй бөгөөд ингэснээр амжилтанд хүрэх магадлал өндөр болж, төөрөлдөхөөс зайлсхийх болно.
- Экспортлогчид боломжит түншүүдтэйгээ утсаар биш, FoodEx зэрэг **хүнсний үзэсгэлэн** дээр биечлэн холбогдохыг зөвлөдөг байна.



2. Зах зээлд нэвтрэх заавар - Вьетнам

Ерөнхий

- Махны импортыг зөвхөн мах, шувууны бүтээгдэхүүний **худалдаа эрхэлдэг Вьетнамын компани** албан ёсоор авах боломжтой.
- Ихэнх импортлогчид **Ханой, Ху Чимин хотод** байрладаг бөгөөд Вьетнамын хойд ба өмнөд хэсэгт төвлөрдөг.
- Нõ Chí Minh хот нь орчин үеийн жижиглэн худалдааны дэлгүүрүүд ихтэй, гаднын хүн ам олонтой тул импортын махан бүтээгдэхүүн, ялангуяа Монголын мах экспортлогчдын хувьд **хамгийн таатай газар** юм.
- Боломжит бизнесийн түншүүдтэй холбоо тогтоох, тэдэнтэй **харилцах зөв аргыг мэдэх нь чухал**.
- Логистик, тээврийн хувьд хамгийн өргөн хэрэглэгддэг нь **авто тээвэр** юм. Улс даяар 320 боомттой тул Вьетнам руу нэвтрэх ачаа тээврийн чухал зам бол **далайн тээвэр** юм.





График 17. Вьетнам дахь түгээлтийн сүлжээ



Зураг 2. Холбогдох худалдан авагч, импортлогч, борлуулагчдын жагсаалт

Компанийн нэр	Импортын бүтээгдэхүүн	Вэбсайт
Asia Shine Distribution	Тос, жигнэмэг, боловсруулсан мах	www.asia-shine.com.vn
Classic Fine Foods	Мах, сүүн бүтээгдэхүүн, гоймон, чанамал	www.classicfinefoods.com
Food Source International	Мах, сүүн бүтээгдэхүүн	www.foodsource.com.vn
Fresh Food	Мах, жимс	www.freshfoods.vn
Good Food	Мах, сүүн бүтээгдэхүүн	www.goodfood.com.vn
High Food	Мах, согтууруулах ундаа, цагаан идээ, жимс	www.hifood.com.vn
Huytuan	Мах	www.huytuanfood.com.vn
La Maison	Мах	www.lamaison.com.vn
Ngoc Cuong	Мах	www.thucphamtuoisong.biz.vn


2. Зах зээлд нэвтрэх заавар - Казахстан

Ерөнхий

- Экспортлогч нь **импортын бүх баримт бичгийг нягт нямбай шалгаж**, Казахстаны экспортын суваг байгуулахаас өмнө Казахстаны хууль тогтоомж эсвэл Казахстаны бүтээгдэхүүний онцлог зохицуулалт / ЕАЭЗ-ийн бодлого, ДХБ-д элсэх / -ийг зөрчихгүй байх ёстой..
- Монгол Улс Казахстантай хиллэдэггүй тул экспортолж буй махыг **Орос, Хятад** хоёрын аль нэгээр дамжуулж тээвэрлэх ёстой. Орос, Казахстаны хооронд авто болон төмөр замын холболт нэлээд сайн байна.



График 18. Казахстаны түгээлтийн сүлжээ



- 2019 оны 7-р сараас эхлэн хэрэгжиж эхэлснээр Монгол Улсын Засгийн газар **Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридор** байгуулах тухай хэлэлцээр хийв. Энэ нь Казахстан болон Монголын харилцаанд чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь Монголын экспортыг Казахстан руу нэвтрүүлэх боломжийг хөнгөвчилдөг.
- Экспортлогчид Казахстаны махны зах зээлд нэвтрэхдээ импорт, **эрүүл ахуй, эрүүл ахуйн дүрэм** журмыг шаардлагатай **логистик, тээврийн хэрэгслийн** талаар мэддэг байх шаардлагатай.
- Нэмж дурдахад импортлогчийн **түгээлтийн сүлжээний** давуу тал, таны **бүтээгдэхүүнийг** харгалзан зөв импортлогчийг сонгох нь чухал юм..

3. Хятадын зах зээлд нэвтрэх бэрхшээлийг даван туулах - Одоогийн гүйцэтгэл

Ерөнхий

- Хятад бол монгол махны хамгийн том импортлогч орон юм. Монголын махны холбооноос мэдээлснээр сүүлийн жилүүдийн махны экспортын **90-95%** нь Хятад руу гарч байжээ.
- Монголын махны холбооноос мэдээлснээр адуу, үхэр, хонь, ямааны махыг Хятад руу экспортлоход нийт **94,500 тонн** махны экспортын квотыг Монголын мах үйлдвэрлэгчдэд олгожээ. Үүнээс **54,500 тонныг** худалдааны ерөнхий ангиллаар, **40,000 тонныг** татвар зохицуулалтын хүрээнд нэмж олгожээ.
- Экспортын эдгээр 40,000 квотыг зуны хуурайшилт, өвөлжилт хүндэрсэн, малын гарц буурсан тодорхой зургаан аймагт олгосон.

Худалдааны ерөнхий ангиллаар экспортлох квот		Экспортын квотыг татварын зохион байгуулалттай Аймаг:	
		Говь-Алтай	
		Баянхонгор	
		Өмнөговь	
		Дундговь	
		Архангай	
		Өвөрхангай	
Адууны мах (хөлдөөсөн)	27,900 тонн		
Дулааны аргаар боловсруулсан үхрийн мах	8,000 тонн		
Хонины мах	6,600 тонн		
Ямааны мах	12,000 тонн		
Нийт квот:	54,500 тонн	Нийт квот:	40,000 тонн
Нийт дүн: 94,500 тонн			

3. Хятадын зах зээлд нэвтэрхэд тулгардаг сорилтуудыг даван туулах – Бэрхшээлүүд ба боломжууд

Бэрхшээлүүд

Боловсруулаагүй махны экспортын хориг: Монголын махны холбооны мэдээлснээр Хятадад зөвхөн **5-6 компани** (нэр нь тодорхойгүй) Монголоос мах/махан бүтээгдэхүүн шууд импортлох тусгай зөвшөөрөлтэй байдаг. Ихэнх мах/махан бүтээгдэхүүн нь дулааны аргаар боловсруулагдсан байдаг учир жижиглэнгийн зах зээлд гаргах боломжгүй байдаг.

КОВИД-19: Махны экспортын квот тогтоосон хэдий ч тахлын улмаас тулгарч буй эрүүл мэнд, аюулгүй байдалын асуудалууд гарч байгаатай холбогдуулан Монгол дахь мах боловсруулах компаниуд 2020 оны 1-р сараас эхлэн **үйл ажиллагаа нь тасалдаж** байгааг мэдээллэв.

Өрсөлдөх чадвар сул: Мах боловсруулдаг олон компаниуд хиам, лаазалсан махан бүтээгдэхүүн гэх зэрэг **нэмүү өртөг шингэсэн мах махан бүтээгдэхүүнийг** экспортлохоор хүчин чармайлт гаргаж байгаа хэдий ч гадаадын үйлдвэрлэгчидтэй өрсөлдөх чадвар маш бага.

Микробиологийн шинжилгээний лабораториуд: Дархан Мийт Фүүдс ХХК-ийн экспортын төлөөлөгчийн хэлснээр (Дархан дахь мах боловсруулалт/ экспортын компани), экспортын үйл ажиллагааг хөгжүүлэхэд саад болж буй хамгийн том асуудал нь **дотоодын микробиологийн шинжилгээний систем** сул байгаатай холбоотой юм.

Боломжууд

Эко махны шошго: Монголын мах боловсруулах компаниуд дэлхийн махны зах зээлд “эко мах” шошгоор дамжуулан томоохон байр суурийг эзлэх боломжтой. Монгол орны ихэнх мал **өвсөөр тэжээгдэж, арилжааны зорилгоор ашиглагддаггүй бөгөөд чөлөөтэй бэлчээрэлдгийн** зэрэгцээ химийн оролцоо бараг байхгүй байдаг. Монголын өвөл хахир хатуу урт байдаг учир зөвхөн эрүүл чийрэг амьтад даван туулдаг. Энэ нь цаашдын нэмэн өртөг шингэсэн мах экспортлох худалдааны хэлэлцээр болон маркетингд сайнаар нөлөөлж байгаа юм.

Халал махны шошго: 415 тэрбум ам.долларын халал-хүнсний үйлдвэрлэл нь Монгол шиг лалын бус шашинтай орнуудаас импортлогдож буй махыг ихээхэн ашиглагддаг. Монгол Улс Иран, Арабын Нэгдсэн Эмират, Кувейт зэрэг орнуудад **халал махны экспортыг нэмэгдүүлэх өндөр чадвартай.** Махыг халал гэж үзэхийн тулд мал нядлагч нь лалын шашинтай байх ёстой. Монгол улс-д Буддын шашин ноёрхдог боловч мусульман шашинтай 100,000 гаруй казахууд байдаг бөгөөд хүн амын 3 орчим хувийг эзэлдэг.

3. Хятадын зах зээлд нэвтэрхэд тулгардаг сорилтуудыг даван туулах – Экспортын хөгжлийн үе шатууд

			 МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ	 中国海关 China Customs	 EMBASSY OF MONGOLIA	 МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ			
Монгол мах боловсруулах компани	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам	Монгол Улсын Гадаад Харилцааны Яам	БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар	Монгол Улсаас БНХАУ-д Суугаа Элчин Сайдын Яам	Монгол Улсын Гадаад Харилцааны Яам	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар	Монгол мах боловсруулах компани	Хятад мах импортлогч компани
Экспортлох хүсэлт (цахим)	Хүсэлтийн урьдчилсан шалгалт	Хүсэлтийн урьдчилсан шалгалт	Дипломат шуудангаар хүсэлтийг илгээх	Хяналт шалгалт, батлах (эсвэл татгалзах) шийдвэр	Шийдвэрийг хүлээн авах, Монгол хэл рүү орчуулах	Шийдвэрийг шалгах	Тус компанид мах экспортлох тусгай зөвшөөрөл олгоно	Хятад руу мах / мах экспортлох (хээрийн хяналт шалгалт тогтмол явагдана)	Мах / махан бүтээгдэхүүн хүлээн авах

- БНХАУ-д мах махан бүтээгдэхүүн экспортлох хүсэлтэй байгаа Монголын мах боловсруулах компаниуд эхлээд албан есны экспортын хүсэлт гаргах шаардлагатай байна.
- Хүсэлт нь цахим орчинд явагдана. Үүний дараа Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам урьдчилсан хяналт шалгалтыг хийж улмаар Гадаад харилцааны яамд хүргэгдэнэ.
- Гадаад харилцааны яам нь энэхүү саналыг дипломат шуудангаар дамжуулан БНХАУ-ын Гаалийн ерөнхий газарт илгээдэг.
- Гаалийн байгууллага нь уг хүсэлтийг нарийвчлан шалгаж, саналыг зөвшөөрөх эс зөвшөөрөхийг шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд гаалийн байгууллага нь тодруулах зорилгоор нэмэлт мэдээлэл авах хүсэлт тавина.
- Гаалийн байгууллагаас гаргасан шийдвэрийг Хятад дахь Монгол Улсын ЭСЯ-д хүргүүлж, монгол хэлээр орчуулж, Гадаад харилцааны яаманд буцаан хүргүүлдэг.
- Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар эцсийн шатны зөвшөөрлийг гаргаж, экспортын лицензийг тус компанид олгоно. Экспортын зөвшөөрлийн дагуу гаалийн байгууллага нь газар дээр нь очиж биет хяналт үзлэг хийдэг.

4. Дүгнэлт ба зөвлөмж – Байгууллага

Махны үйлдвэрлэлийн салбарын бүтцийг нэгтгэх


Монгол Улс экспортын салбарыг амжилттай байгуулахын зэрэгцээ нийлүүлэлтийн тогтвортой урсгалыг хадгалахын тулд оролцогч талуудыг зохицуулах, хамгаалах бодлогыг бий болгох ёстой

Эрүүл мэндийн үзлэг, эмчилгээний аргаар чанарыг сайжруулах

Эрүүл мэндийн албан ёсны байгууллагатай хамтран ажиллаж, мэргэжлийн малын эмч нарын төлөвлөгөөт үзлэг байх нь чухал юм

Уг зах зээлийн мэдээллийн системийг бий болгох, хэрэгжүүлэх

Худалдааны холбогдох статистик мэдээлэл, олон улсын махны зах зээлийн мэдээлэлтэй экспортлогч нь махны экспортыг илүү үр дүнтэй болгож амжилтанд хүрэх болно.



Тээвэрлэлтийн хяналт, ложистик, сав баглаа боодлын шийдлүүд

Монгол Улсын тээвэр, ложистикийн салбар нь газарзүйн байрлалаас шалтгаалан үр ашиг багатай, зардал ихтэй байдаг. Тиймээс илүү үр ашигтай тээвэрлэлт хийхийн тулд шинэ зам барих, шинэчлэх ажлыг барилгын компаниудтай хамтран хэрэгжүүлэх нь нэн чухал юм.

Махны тоо хэмжээ гэхээсээ илүү чанарыг сайжруулах

Чанарыг сайжруулахын тулд сүргийн тоог хязгаарлахад холимог соёл, эдийн засгийн хүчин зүйлүүд хүндрэл учруулдаг

Малын идэш тэжээлийн аж ахуйг хөгжүүлэх

Хямд үнэтэй малын тэжээл байхгүйгээс шалтгаалан бэлчээрийн бус цаг үед малчдад ихээхэн бэрхшээл учруулж байна.

Мал аж ахуйн гаралтай орлуулах бүтээгдэхүүнийг хөгжүүлэх

Малчдад мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг төрөлжүүлэх, өргөжүүлэх, бизнесийн түншлэл бий болгох, маркетингийн сүлжээг хөгжүүлэх талаар хангалттай зааварчилгаа өгөх нь чухал юм.

4. Дүгнэлт ба зөвлөмж – Арилжаа

Монгол улсын мах, махан бүтээгдэхүүнийг үзэсгэлэн худалдаа, арга хэмжээний салбарт сурталчлах

Олон улсын болон дотоодын бизнесийн шинэ түншлэлийг татахын тулд дотооддоо өргөн цар хүрээтэй үзэсгэлэн, наадам зохион байгуулах

Экспортын мах, махан бүтээгдэхүүнийг дотоодын стратегийн түншүүдээр дамжуулан түгээх

Уламжлалт зах зээлийн тухайд, Монголын мах үйлдвэрлэгчид экспортолж буй махаа борлуулах зорилгоор зорилтот зах зээл дээр өөрийн дэлгүүр, махны үйлдвэр байгуулж болно.

Зорилтот зах зээлийн хуваарилалтын сувгуудыг судлах

Өөрийн нэрийн брэндийг хөгжүүлж, монгол махыг сурталчлах нь онлайн дэлгүүрүүдээр дамжуулан мах шүүд худалдан авах сонирхлыг нэмэгдүүлэхэд тусална.